

“Яриа” зохиолын дүр, дүрслэлийн онцлог

Д.Галбаатар*, Г.Нарантунгалаг**

“Яриа” зохиолын бүтэц, зохиомжийн онцлогоос шалтгаалан дүр нь: амьгүй эд юмсыг амьдчиллын аргаар дүрсэлж тэдгээрийн үйлдлийг бус харин хүншүүлсэн баатруудынхаа бодол санаа, хүсэл зорилгыг харилцан ярианы хэлбэрээр нээхэд, амьтдын хоорондын зөрчил маягаар хүний явдлыг далд ёгт үлгэрчлэлийн аргаар нээсэн, мөн амьтад ба хүн хоёрын хоорондын зөрчил мэтгэлцээний маягаар зохиомжилсон холимог дүрийн системтэй, үзэл, үйлийн зөрчилт талын ямар нэг шалтгаанаар юмуу нэгэн зорилго, хүсэл зорилго бүхий анги гарал бүхий хүмүүсийн үзэл бодол хоорондын харилцааны ижил төсөө байдлыг илтгэсэн дүрийн хэд хэдэн төрөлд хуваан үзэж болох билээ.

Ялангуяа “Яриа” зохиолын амьтан юмс, хүн баатар бүхий бүтцэд сөргөлдөгч талын зөрчил бус харин нэг анги, давхрага, хүсэл бодолтнуудын хоорондын зөрчил мэтээр илэрхийлдэг бол дүрийн бусад систем бүхий “яриа” ба “жүжиг”-т сөргөлдөгч анги хэсэг бүлгийн эсрэг тэсрэг байр суурийг үндсэн зөрчил болгож үзүүлсэн онцлог бий.

Яриа зохиол нь бичгийн уран зохиолын бие даасан төрөл зүйл төдийгүй нийгмийн хөгжлийн шилжилтийн онцлог үе шатуудыг дамжиж хөгжсөн учраас түүний урлал зүй, ялангуяа уран сайхны хэрэглүүр, өгүүлбэр зүйн уран маяг, утга шилжүүлэх ёс, үгийн сангийн сонголт, хэл найруулга нь тухайн үеийн аман ярианы найруулгын онцлогийг хадгалж иржээ.

Судлаачид 1920-30-аад оны уран зохиолд амьдралыг идэвхгүй хуулбарладаг натуралист бичлэг нэлээд тохиолддог тухай тэмдэглэсэн байдаг. Натурализм нь амьдралын бодот үнэнийг мөрдөн бичих зарчимд суурилдаг тул уран сайхан, дүр дүрслэлийн уран сайханд төдий л ач холбогдол өгдөггүй, шүүмжлэлт аяс хандлага давамгайлсан тал харагддаг. Гэхдээ энэ нь 1920-30-аад оны “Яриа” зохиол ба энэ үеийн шог ший, жүжгийн анхны бүтээлүүдэд уран сайхны сонирхолтой шийдэл, уран дүрслэл, хэлний тансаг байдлыг үгүйсгэж байгаа хэрэг бус, харин төрөл зүйлийн онцлог, зориулалт, бичлэгийн хэлбэрээсээ шалтгаалж асныг тайлбарлахыг хичээсэн хэрэг юм. Доктор Л.Түдэв Үлгэр-өгүүллэгийн тухайд сонирхолтой дүгнэлт хийжээ. Тэрбээр:

“-Ардын аман зохиол сайн мэддэг, хуучин утга зохиолын зарим дурсгалыг уншсан хүнд үлгэр бол хоёр үндсэн ач тустай байжээ. Нэгд, боловсрол багатай, бичиг муу мэдэх хүмүүст суртал нэвтрүүлэхэд үлгэр нийтэд хүртээлтэй, ойлгомжтой байж. Хоёрт, реализмын утга зохиол бага мэддэг, туршлага нимгэнтэй залуу зохиолчдод үлгэрийг өгүүллэг болгон боловсруулах ажил уран бүтээлийн сургууль дадлага болж”¹ гэж дүгнэсэн нь бидний үзэл, байр суурьтай нэлээд талаараа холбогдох юм.

Яриа зохиолын уран сайхны онцлогийн талаар зарим жишээг үзье. Д.Нацагдорж “Хөгшин хүний өгүүлэл” зохиолынхоо төгсгөлд: Хөдөө орон нутгаас Улаанбаатар хотод ирсэн нэг өвгөн ханиад хүрээд, эм залахаар явж байтал “Эрүүлийг хамгаалах газар”-ын хашаа дайралджээ.

-Ийм газрыг чинь ямар буянтай хүн байгуулсан юм бэ? гэвэл

-Буянтай хүн ч бус, өршөөлтэй засаг чинь байгуулсан юм гэнэ² гэжээ. Энгийн харвал хоёр хүний энгийн ярианы хэсэг юм. Харин дүрслэл талаас нь үзэхүл хэн нэг “буянтай хүн бус” гэсэн эхний субъектыг үгүйсгэх, харин “өршөөлтэй засаг чинь” гэж тодотгосон хоёрдугаар субъектыг нотлох хэрэглүүр болгон ашиглаад улмаар энэ хоёр дүрслэлээ харшууллын уран маяг болгон холбож, зохиолынхоо ерөнхий утга санааг тов тодорхой болгосон нь хэн нэг буянтны хүч гэж амьдралыг ойлгодог асан хуучны хүлцэнгүй үзэл бодлыг үгүйсгэн өршөөлт шинэ засгаараа бахархсан өнгө аяс, сэтгэлийн хандлагыг нээн илэрхийлж чадсан аж. Мөн зохиолчийн “Нянгийн яриа” шүлэглэсэн яриа зохиолд “яр тэнбүү”, “хижиг” хоёр өвчний нянгийн тус тусын зорилгыг бадаг бүрт тэгш хуваарилан яриа хэлбэрт оруулж, тэдгээрийг “салхи хөлөглүүлэн”, мөн нэг хоосон орон зайд тусгаарлан уулзуулж, нэг нь хот хүрээ газар руу, нөгөө нь хөдөө сэлүү аюулгүй газрыг зорьж яваад бие эсэсээ хүрээ хот, хөдөөгүй “хүний цусанд эм хийж, манийг алаад байх болов”³ очих газаргүй сандарч буйг нэгэн зүгт хамтдаа одохоос өөр аргагүй болж байгааг:

* МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын Sc.D профессор

** МУИС-ийн ШУС-ийн ХУС-ын докторант

¹ Л.Түдэв МАХН-аас утга зохиолын тухайд явуулсан бодлого. УБ. 1971 38-39-р тал

² Б.Содном “Нацагдоржийн намтар зохиол” УБ.1966 185-р тал

³ Д.Нацагдорж “Зохиолууд” УБ. 1961. 179-р тал

Хоёр нян хоорондоо ийн ярилцаад: “хурдан хурдан” гэлцээд “Хуй салхи хөдөлгөөд хуврагийн оронд очих зам...-аар⁴ хийсэн одох зэрэг нь дээрх аргын нэг хувилбар болох эсрэгцүүлэл хийгээд мөн чанарыг далдуур адилтгах аргаар нээн дүрсэлсэн нь “хурдан хурдан” гэлцээд “хуй салхи хөдөлгөөд” зэрэг цаг хугацааны эрхээр бачимдаж яваа нянгуудын зовлон хийгээд дотоод ертөнцийн бачим сандруу шинжийг илтгэхийн ялдамд, үүгээрээр хөдөлгөөний шинэ мэдрэмжүүдийг үүсгэж чадахуйц үгс ба үйлдэл хөдөлгөөнийг хамсруулж хэрэглэсэн нь зохиолын баатруудын хэв шинж, сэтгэл зүй дотоод ертөнцийн байдлыг оновчтой зөв нээх, зохиолын өрнөлийг эрчимжүүлж уран хошин аяс, ёгт далд, шүүмжлэлт санааг илэрхийлсэн нь зохиолчоос өөрийн ард түмнээ гэгээрүүлэн сэнхрүүлэх, суртал нэвтрүүлэх хүсэл зорилготой нь яв цав нийлсэн уран дүрслэл болжээ.

Иймэрхүү хэв маягийн уран дүрслэлүүдийг бие биеэсээ илүү их эрдэм чадалтай хэмээн маргаж буй бичгийн гурван хэрэгслийн маргаанаар хэрэггүй зүйлд өөрийг ихэд дөвийлгөн тоох зан суртахууныг ёгтлон дүрслэхдээ бийр янтайгаар хуучин цагийн сэхээтний хуучинсаг зан байдал, үзгээр шинэ сэхээтний хувьсган шинэчлэгчийн байр суурь, үзэл санааны сөргөлдөөнийг /зөрчил/ давхар нээсэн Чинбатын “Бийр, үзэг, харандаа гурвын үлгэр” /1929/ энэ мэт нийгэм-амьдралын өөр өөр салбар дахь эмзэг асуудлуудыг хөндсөн С.Буяннэмэхийн “Том, жижиг тугалган үсгийн уран хошин яриа”, Занабазарын “Таван цогцос харилцан тэмцсэн нь” олон тооны яриа зохиолуудаар төлөөлүүлж, ур хийц, утга агуулга, уран хошин егөө, ёгт санааг “яриа” хэмээх өвөрмөц бүтэц бүхий олон тооны зохиол 1920-30 оны уран зохиолд бие даан хөгжсөн ажээ.

С.Буяннэмэх дээрх зохиолдоо өөрсдийнхөө ном хэвлэлийг бүтээхэд өөр өөрийн гүйцэтгэх үүрэг, ач тус ихийг товойлгон тодорхойлж, өрсөлдөн магтаж, өөр зуураа маргах том хар үсэг, арван хоёртын жижиг үсэг хоёрын маргаан хийгээд тэр нь арван зургаатын дунд үсэгний оновчтой сургаалын үр дүнд цугаар эв зүйгээ олж буйг өгүүлэхдээ, далдуур сонин хэвлэлийн олон талын ашиг тусыг ухуулж, ялимгүй зүйлээр өөрийг дөвийлгөх хүсэл хийрхэл хаа сайгүй дэлгэрснийг ёгтлосон юм. Энэ яриа дахь: Том хар үсэг:

“- Би бол тодорхой мөртэй, тун их хүндтэй, толгой тэргүүний зэрэгт явдаг”⁵ гэх мэтээр өөрийн үнэ цэн, нэр хүнд, ашиг тусыг уран тоочлогын аргаар дүрслэхдээ шүлэглээгүй боловч шүлэгтэй адил эхэн ба адгийг давтан холбож тодорхой хэмнэл үүсгэн, өөрийн хөргийг товч тодорхой илэрхийлж цааш нь: “Ахаа гэж хүндлэхийг мэдэхгүй, тэргүүн гэж тэтгэмжлэхийг мэдэхгүй”⁶ зэрэг үгс нь Том үсэгний өөрийг ихэд бодсон сагсуу зан авирыг илэрхийлсэн нь оновчтой, ойлгож тогтооход хялбар, сонирхолтой ёгтлол болсон бол үүнийг сонсоод Арван хоёртын жижиг үсэг түүнийг “-Хэвлий чинь бүдүүн, хэрэг чинь бага, хэвлэл сонин дээр тавихад, хэдхэн мөрд л хэмжээгүй газрыг эзэлж”⁷ байдаг зэргээр шүүмжлэн мэтгэсэн дүрслэл шүлэглээгүй ч шүлэг мэт нарийн хэмнэл үүсгэж, уг дүрээ хөрөгчлөн тодруулж, далдуур шүүмжлэн цэцлэхэд: Том үсэг: “-Чи дэмий бүү цэцэрхэгтүн. Намайг үгүй бол чамайг хэн үзэх вэ. Эхгүй бол хүүхэд хаанаас гарах вэ. Захгүй бол дээл яахин бүтэх вэ. Би хэдий бүдүүн ч...”⁸ зэргээр мэтгэн баалсан дээрх дүрслэлийн өнгө аяс нэлээд өөрчлөгдөж, улмаар нэгэн логикт захирагдсан ахиулал болон алслалтын уран маягийн үүргээр зөрчлийг хурцатган гүн ухааны аястай болгож буй нь ардын аман зохиолын дайралцаа үг, цэцлэлийн уран найруулгын уламжлалыг бүтээлчээр ашиглажээ гэдэг нь тодорхой харагддаг. Улмаар Жижиг үсэг: “- ..Гэгээн тунгалаг бодлоготон, гэрэлт тодорхой эрдэмтэн, цэцэн сэргэлэн ардууд, сэхээтэн мэргэн хүмүүс намайг үзэхээс чамайг үздэггүй болой”⁹ зэрэг дүрслэг хэллэгүүд нь ардын ерөөл магтаалын “харилцаа цэцлэлийн хэв шинж”-ийг санагдуулахуйц шүлгийн хэллэг, хэлбэр галбир, хэмжээ хэмнэл, уламжлалыг чөлөөтэй ашигласан нь энгийн хүмүүст ойлгоход ойр, бас ч уг мэтгэлцээ зохиолынхоо сонирхогдох тал, маргалдагчдын сэтгэл хөдлөлийн байдлыг уран сонголонтой болгоход чухал үүрэг гүйцэтгэжээ. Эл зохиолын дүрслэл ерөнхийдөө шүлэглээгүй шүлэг, оноч мэргэн үг, уран дүрслэл, ёгт хэллэг, эсцлэл хосолсон сонирхолтой бүтээл юм.

Ц.Дамдинсүрэнгийн “Янагийн үнсэлт” хэмээх сонин зохиол буй. Эл зохиол бүхэлдээ харилцан яриа, мөн бяцхан хүүрнэл /төгсгөл-дүгнэлт/-ээс бүтжээ. Энэ зохиолын тухай профессор Д.Цэнд “Янагийн үнсэлт” мэтийн натуралист дүрслэл бүхий зохиол бий”¹⁰, Г.Жамсранжав “С.Буяннэмэхийн “Моторт тэрэгний хэрүүл” зэрэг ёгт өгүүллэгийг мөн ингэж хэлж болно... үнэнийг урнаар илтгэхийн оронд болхиор хуулж, заваан үг, хараал зүхэл их хэрэглэсэн”¹¹ зэргээр шүүмжлэн тайлбарлаж байв. Уг зохиол нь:

“-Ай хүү минь, миний хүү?

-За за юү гээвээ? Эргэж хараад ирэв.

-Чи надад дуртай юу?

-Дуртай.

-Надад хайртай юу?

-Хайртай.

4 Д.Нацагдорж “Зохиолууд” УБ. 1961. 05-р тал

5 С.Буяннэмэх “Түүвэр зохиолууд” УБ.1968 96-р тал

6 Мөн тэнд

7 Мөн тэнд

8 Мөн тэнд

9 С.Буяннэмэх. Түүвэр зохиол 1968. 96р тал

10 Д.Цэнд. Монголын уран зохиол. УБ. 1965 141-р тал

11 Г.Жамсранжав. Анхны алхам. УБ. 1969. 103-р тал

-Үнэхээр үү?

-Үнэхээр.

-За чингэвэл намайг гурав дахин үнс! хэмээн хүзүүгээр чанга тэвэрч инээмсэглэн мишээлээж бүхий царай юугаа алгуурхнаар ойртуулж ахуйд хоёр биеийн цог мэдрэл хямралдаж, шүд ам давжигнатал чичрэн хоёр бие лугаа бүх чадлаар чанга тэвэрч, нэгэнт цэнгэлийн үнсэлтийг авалцаж, хоёр хушуугаа нийлүүлэн шимэлцэхийн үед нэг мөсөн амрагийн зүрх уяраад, янагийн гал шатаж, оюун ухаан сэлтээр энэхэн зуурын буданд төөрөгдөж, гадны айлын хүн ирж харахад мэдсэнгүй наалдсаар нэг цагийн төдий болж, сая арайхан салалцахад дэргэд нь ах дүү, эцэг эх гайхан зогсжээ”.

Хоёр залуу ичингүйрэн цочиж гадна зугатан оджээ.¹² гэсэн ярианд суурилсан бичил зохиолын хэлбэр юм. Янагийн үйлийн үүтгэлд автсан залуусын харилцаа шивнээний аяс анир, үйлийн үргэлжлэлд өдөөсөн гурван үнсэлт “хоёр биеийн цог, мэдрэл хямралдаж”, “шүд, ам давжигнатал чичрэн”, “хоёр бие лугаа тас тэвэрч”, “хоёр хушуугаа нийлүүлэн шимэлцэхийн үед”, “янагийн гал шатаж”, “энэхэн зуурын буданд төөрөгдөж” /утга шилжүүлэх, хүчжүүлэх, харшуулах уран маягийг мэдэрхүйд нөлөөтүүлэн найруулсан нь зохиолыг уран сонирхолтой болгожээ/ ахуйд дэргэдээ хүмүүс ирэхийг мэдээгүйдээ ичингүйрэн зугатаах залуусын хөгжилтэй дур хүслэнгийн эрчимт, хяслант байдлыг дүрслэхдээ хэт махбодчилон үйлдэл бүрийг угсруулан ахиулсан гүнзгийрэлт нь хүмүүний ахуй хийгээд оюуны хяналтаас ангид огт өөр цэвэр физиологийн болзолт бус нөхцлийг харуулсныг “...хүний ухамсаргүй үйл ажиллагааг шохоорхох... биологийн зөн совинт чанар, төрмөл бус рефлекс чанар уран сайхны практикт голлох үүрэгтэй”¹³ гэж үздэг өрнөдийн биологизмын чиглэлийн онол зарчмын үүднээс үзвэл эл бичил яриа зохиолыг натурализм, садар самууны гэх мэтээр гүйсгэх боломжгүй юм.

Профессор Д.Галбаатар эл зохиолыг натурализмын дотоод урсгал болох биологизмын урсгалд хамаарах хийгээд уран сайхан чанарын талыг “Хүний биологийн нууцлаг үйлдлийг эрчимт орон зай руу гүн нэвтэрсэн эдгээр дүрслэлүүдээс хайр дурлалын оргил агшин ба хүсэл цэнгэл, тайтгарал нь хэн хүний биологийн хэрэгцээг тэтгэгч нийтлэг мөн чанар, өвөрмөц маягийн эрчимт дур хүслэн, тааламжит байдал уншигчдад төрүүлэх нь ойлгомжтой зүйл. Зохиолоос төрөх сэрэл, мэдрэхүй, ичингүйрэл, дурсамж, дур хүсэл, тайтгарал зөвхөн уншигчийн сэтгэл зүрхнээ үүсч байгаа нь уг бүтээлийн ур чадварыг төдийгүй урлагийн үнэ цэнэт зүйлс тээснийг илтгэдэг”¹⁴ гэжээ.

Үнэхээр энэ үеийн яриа хэлбэрийн зохиолуудад натураль бичлэгийн ийм шинж тэмдэг тод бөгөөд энэ нь монголын уран зохиолын өв сан төдийгүй залуу уран зохиолчдын хувьд тийм өнгийж болохгүй орон зай, буруу зам байгаагүй бөгөөд “дүрслэл дэх негатив мөн чанарын үүргийг дутуу үнэлэн, позитив мөн чанарт илүү ач холбогдол өгдөг”¹⁵ тийм тодорхой цаг үе үндэстний уран зохиолд тохиолддогтой холбоотой юм.

1920-30-аад оны “Яриа” зохиол хэлний талаасаа хуучин бичиг зохиолын хэлний уран яруу найруулгыг ашигласан, дүрслэх болон яруу хэрэглүүрийг оновчтой хэрэглэсэн байдаг ч ерөнхийдөө бодит байдал голчлон хөнддөг.

“Яриа” зохиолд байх нэг онцлог бол хар ярианы найруулга, бичгийн хэлний аялгыг их хэрэглэсэн нь зарим тохиолдолд уран сайхны болон хэлний соёлын хувьд сул дутагдалтай болгодог тал ажиглагддаг. Мөн зөвхөн драм буюу жүжигчилсэн зохиолд ч биш, энэ нь нийгмийн шинэ нөхцөл байдал өгүүлэлт зохиолын хөгжилд шилжилтийн үе таарч, мөнхүү тухайн үед нийгмийн хөгжлийн түвшин, уран бүтээлийн шинэ найруулах ёс бүрэлдэн төлөвшөөгүй, шинэ залуу уран бүтээлчдэд ур зүйн туршлага дутагдалтай асантай холбоотой байна.

“Яриа” зохиол нь дүрийн хувьд хүншүүллийн аргыг ашиглан дүрсэлсэн амьтад, юмсын дүр голлох байртай, харин хүний дүрийг ёгтлол, төлөөлөл, бэлгэдлийн хэлбэрээр хослуулсан байх төдийгүй хүн, амьтан, юмс өөр хоорондоо зөвхөн хүний хэлээр чөлөөтэй харилцан хэлэлцдэг явдал юм. Тухайлбал: Агваанхайдавын яриа зохиолуудад үхэр, хонь, ямаа гурав өөр хоорондоо хэлэлцэхийн хамт гэлэн лам хийгээд яргачинтай хүний хэлээр ч чөлөөтэй хэлэлцдэг нь үлгэр, домгийн арга зүйн нэг нөлөөлөл юм. 1920-30-аад оны үе хамаарах Г.Навааннамжилийн “Хулгана зурамын яриа” зохиолын хулгана, гэлэн ламтай хэлэлцсэн яриа, эсвэл С.Буяннэмэхийн “Том, жижиг тугалган үсэг”-нүүдийн амьдчилал, уран цэцэн, учир ухуулсан ярианы хэлбэр эртний үлгэрийн амьтан баатруудад түгээмэл байдаг төдийгүй зохиолыг сонирхолтой, уран сайхан болгодог дүрслэлийн үндсэн аргын нэг юм. “Үнэг, туулай, зараа гурвын үлгэр”, “Далантай өвгөн”, “Болдоггүй бор өвгөн” ардын богино үлгэрийн дүрийн системтэй ижил төдийгүй ихэсгэл багасгал, хэтрүүлэл, ёгтлол, егөөдлийн уран маягуудыг баялаг хэрэглэж байв.

Гэхдээ 1920-30-аад оны “Яриа” зохиолуудад нийтлэг байдаг гол дутагдал бол уран сайхны үүргийг бага анхаарч сурталчлах, ухуулах, шүүмжлэн сэнхрүүлэх талд их анхаарснаас уран дүрслэлийн хувьд ардын үлгэрийн уран чадвараас дутмаг шинжтэй байгаа нь залуу зохиолчдын урлах туршлагатай холбоотой юм.

Орчин үеийн богино хэмжээний хүүрнэл зохиолд дүрийн ийм систем байдаг боловч хүн хүнийхээ явдлаар, харин амьтан юмсын дүр нь тэрхүү гол баатрын зан төрх, үзэл бодол, явдал түүхийг нэмэн тодотгох үүрэгтэй

¹² “Уран үгсийн чуулган” 1929 УБ. 2013 69-р тал. Монгол бичгээс хөрвүүлж, өмнөтгөл бичиж, эрхлэн хэвлүүлсэн Г.Галбаяр

¹³ История Французской литературы. М. 1981 стр 100

¹⁴ Д.Галбаатар Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд. УБ. үүүб. үйб-р тал

¹⁵ Гульельми А. Назавать вещи своими именами. Вкн: “Группа 63”. М. öjšü. стр 63-64

Д.Галбаатар, Г.Нарантунгалаг

хоорондоо хэлэлцдэггүй баатрууд болж хувьссан байна. Тухайлбал С.Эрдэнийн “Өнчин янзага” өгүүллэгт эзнийх нь эндүүрч эхийг буудсан өнчин янзагатай дассан анч Барс нохой хоёрын нөхөрлөлийн тухай өгүүлсэн боловч түүний эзэн анч өвгөний дүрийн сэтгэл зүйг нээхэд л үүрэгтэй оролцож байна. Өөрөөр хэлбэл хүн хүнийхээ явдлаар, нохой, янзага амьтныхаа жамаар /инстинкт/, зөвхөн агуулга утга санааг нэгтгэхэд л үүрэгтэй болохоос бус үлгэрийнх шиг харилцан хэлэлцэж, хамтран үйлдэхгүй болж хувьссан байна.

SUMMARY

Oral narratives employ anthropomorphic imagery, in which animals and objects act as primary characters, while human characters take forms that combine allegory, metaphor, and symbolism, and where humans, animals, and objects communicate freely amongst themselves using human speech.

A common shortcoming of *varia* narratives published in the 1920s and 1930s is their lack of attention to literary function, with a greater emphasis on propaganda, critique, and didacticism. The lower literary refinement of imagery in these works, as compared to traditional legends and stories, can be related to the level of experience of their young authors.

НОМ ЗҮЙ

1. Буяннэмэх С. Түүвэр зохиол. УБ.1968
 2. Галбаатар Д. Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд. УБ.2001
 3. Гульельми А. Назавать вещи своими именами. Вкн: “Группа 63”. М.1986
 4. Жамсранжав Г. “Анхны алхам” УБ.1969
 5. Жамсранжав Г. “Шинэ замаар” УБ.1978
 6. История Французской литературы. М.1981
 7. Лувсанвандан С. “Монголын орчин үеийн уран зохиолын онол, түүхийн асуудлууд” УБ. 1973
 8. “Монголын орчин үеийн уран зохиолын түүх” I боть. УБ. 1985
 9. Нацагдорж Д. “Зохиолууд” УБ.1961
 10. Содном Б. “Нацагдоржийн намтар зохиол” УБ.1966
 11. Түдэв Л.МАХН-аас утга зохиолын тухайд явуулсан бодлого. УБ.1971
 12. Уран үгсийн чуулган. 1929 УБ. 2013 Монгол бичгээс хөрвүүлж, өмнөтгөл бичиж, эрхлэн хэвлүүлсэн
- Г.Галбаяр
13. Цэнд Д. Монголын уран зохиол. УБ.1965

Characteristics of image and imagery in *varia* narratives